



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4.1, Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 3.7, 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэй байхаар тогтоож, нийт албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. “Ёс зүйн дэд хороо”-ны ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хууль тогтоомжид заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, ажлын тайлан мэдээг холбогдох газарт тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Л.Батзориг)-д үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаа, хувь хэмжээгээр олгохыг Санхүү төсвийн асуудал хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Өсөхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Хонгорзул)-т даалгасугай.


5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/127 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Т. Адам* ДАЛТАНЦЭЦЭГ



1526 010051

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20²⁶ оны ⁰³ дугаар сарын ³¹-ны
өдрийн ⁴⁰⁷ дугаар тушаалын хавсралт



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ- ЭМ, ЭМНЭЛГИЙН
ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН “ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО”-НЫ
БҮРЭЛДЭХҮҮН**

Ёс зүйн дэд хорооны дарга: Хуулийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн Л.Батзориг

Гишүүд: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын
ахлах байцаагч Г.Номин

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын
байцаагч А.Номиндарь

Эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт,
өртөг үр дүнгийн судалгааны асуудал
хариуцсан мэргэжилтэн Б.Тэмүүлэн

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт,
тохируулгын асуудал хариуцсан
мэргэжилтэн Б.Санж-Очир

Оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тоног
төхөөрөмж, протез ханган нийлүүлэх,
үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудал
хариуцсан мэргэжилтэн Б.Амарсанаа

Нарийн бичгийн дарга: Эмийн зохистой хэрэглээний асуудал
хариуцсан мэргэжилтэн У.Соёл-Эрдэнэ